



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 247

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлах боломжгүй болсон 232,360,120.00 (хоёр зуун гучин хоёр сая гурван зуун жаран мянга нэг зуун хорин) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Нямтуул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001827

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 06 дугаар сарын 1-ны өдрийн
А.Н.А. дугаар тогтоолын хавсралт



"Баруун бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар | Үйлдвэр лэсэн/ ашиглал тад орсон он | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ /төгрөг/ | Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/ | Үлдэх өртөг /төгрөг/ | Сэргээн босголтын зардал /төгрөг/ | Худалдах доод үнэ /төгрөг/ |
|-----|--|---|-----------------------|--|--|-------------------------|--|--|
| 1 | "Хьюндай верна", 57-69 УВА, суудлын, КМНСМ41АР7U153928 | 2007/2011 | 292638 | 11,000,000.00 | 11,000,000.00 | 0 | 0 | 2,500,000.00 |
| 2 | "Ландкрийзер-200", 05-50 УВА, суудлын, JTMHU09JXA5034907 | 2010/2011 | 415587 | 102,800,000.00 | 102,800,000.00 | 0 | 0 | 6,000,000.00 |
| 3 | "ХСМГ кран", 13-83 УВА, тусгай, 20070914 | 2007/2011 | 194920 | 107,560,120.00 | 107,560,120.00 | 0 | 0 | 6,000,000.00 |
| 4 | "Тоёота Дула", 01-11 ХОА, ачааны, BU212- 0109465 | 1999/2009 | 221899 | 11,000,000.00 | 11,000,000.00 | 0 | 0 | 3,000,000.00 |
| | Нийт дүн | | | 232,360,120.00 (хоёр зуун гучин хоёр сая гурван зуун жаран мянга нэг зуун хорин) | 232,360,120.00 (хоёр зуун гучин хоёр сая гурван зуун жаран мянга нэг зуун хорин) | 0 | 0 | 17,500,000.00 (арван долоон сая таван зуун мянган) |